

# **Тоон гарын үсгийн тухай хуулийн үзэл баримтлал**

## **Нэг. “Тоон гарын үсгийн тухай” хуулийн төсөл боловсруулах шаардлага, үндэслэл**

Монгол Улсын нийгмийн амьдралын бүх салбарт МХТ эрчимтэй нэвтэрч үйл ажиллагаандаа ашиглах болсноор цахим хэлбэрээр өгөгдөл солилцох, дамжуулах, хүлээн авахтай холбоотой хууль зүйн цоо шинэ харилцаа үүсэн хөгжиж нийгмийн бүх субъект оролцдог боллоо. Цахим хэлбэрээр өгөгдөл солилцох нь төрийн удирдлагыг үр нөлөөтэй болгох, төсвийг хэмнэх, эдийн засгийг хөгжүүлэх, иргэдийн эрх, эрх чөлөөг баталгаажуулахад онцгой нөлөө үзүүлж байна. Тиймээс энэ харилцааг үндэсний болон олон улсын эрх зүйн түвшинд зохицуулах онцгой зохицуулалт шаардагдаж байна.

Цахим хэлбэрээр баримт бичиг солилцох нь цаасан тээгч дээрх баримт бичиг солилцохоос эрс ялгаатай. Ажил хэргийн харилцаа, төрийн удирдлагад цахим хэлбэрээр өгөгдөл, баримт бичиг солилцох ажиллагааг нэвтрүүлснээр маш олон давуу тал, хэмнэлт гардаг боловч түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн зөвийг баталгаажуулах, илгээсэн этгээдийг хөдөлбөргүй адилтган тогтоох асуудал урган гардаг. Энэ асуудлыг тоон гарын үсгийн хэрэгслүүд ашиглах замаар шийддэг. Дэлхийн улсуудад тоон гарын үсэг хэрэглэх асуудлыг 1990 оноос эхлэн хуульчлан зохицуулсан байдаг боловч манай улс энэ талын зохицуулалт байхгүй, өнөөг хүртэл нийтийн түлхүүрийн дэд бүтэцгүй, гэрчилгээжүүлэх байгууллагагүй байгаа нь цахим засаг, цахим бизнес, цахим нийгэм, мэдээллийн технологийн хөгжлийг боогдуулаад зогсохгүй олон улсын харилцаанд ижил тэгш оролцох, бусад улстай цахим өгөгдөл солилцох боломжгүй болгож байна. Тоон гарын үсгийн тухай хуулийг батлан гаргах эрх зүйн болон практик шаардлагууд эндээс урган гарч байна.

### **1.1. Эрх зүйн шаардлага**

Монгол улсад тоон гарын үсгийн зохицуулалт байхгүйн улмаас төрийн удирдлагад цаасгүй технологи нэвтрүүлэх, цахим бизнес хөгжүүлэх, хувь хүний мэдээллийн эрх, эрх чөлөөг хангах, олон улсын түвшинд цахим баримт бичиг солилцоход ихээхэн саад тотгор учирч байна.

Цахим баримт бичигт агуулагдаж буй мэдээллийн үнэн зөв гэдэг нь баталгаатай тохиолдолд төрийн удирдлага, бизнесийн үйл явцад цахим харилцаа, баримт бичгийг

өргөн ашиглах, цахим хэлцэл хийх боломжтой болдог. Цахим баримт бичгийн үнэн зөвийг баталгаажуулдаг сонгодог шийдэл болох тоон гарын үсгийг хэрэглэх нөхцөл, зарчим, гэрчилгээжүүлэх байгууллага, тогтолцоо, тавигдах шаардлагуудыг хуульчлан тогтоож чадсанаар Монгол улсад цахим засаг, бизнес, нийгэм хөгжих суурь тавигдаж, олон улсын түвшинд бүх талаар харилцах боломжтой болно.

Цахим тоон гарын үсэг ашиглах үед эрх зүйн харилцаанд оролцогчдын цоо шинэ эрх үүрэг үүсэж, тоон гарын үсгийн үнэн зөвийг баталгаажуулах тусгай байгууллагууд байгуулагддаг. Эдгээр байгууллагад тавигдах шаардлага, тусгай зөвшөөрөл, эрх үүргийг хуульчлан тогтоох зайлшгүй шаардлагатай. Эдгээр субъектийн харилцааг зохицуулах эрх зүйн акт нь хууль байна. Энэ хуулиар тогтоосон эрх зүйн механизмыг хэм хэмжээ тогтоосон бусад актуудаар нарийвчлан зохицуулна. Энэ хуулийг батлан гаргах эрх зүйн шаардлага эндээс урган гарч байна.

Түүнчлэн цахим тоон гарын үсгийн харилцаанд оршиж буй саадыг арилгах, цахим засаг, бизнесийн хөгжлийг хангахын тулд дэлхийн бусад улсын тоон гарын үсгийн хуулиудтай уялдуулан нийцүүлсэн эрх зүйн зохицуулалтыг цаг алдалгүй батлан гаргах шаардлага тулгарч байна.

## **1.2. Практик шаардлага**

2001-2009 оны хугацаанд Монголын интернет хэрэглэгчдийн тоо 1 саяд дөхөж, цахим бизнес, банкны үйлчилгээнд бүртгүүлсэн, үйлчилгээ авдаг хүмүүс 300000 хүрч, цахим гааль, цахим татварын үйлчилгээ авдаг хувь хүмүүс, хуулийн этгээдийн тоо 200000-д хүрлээ. Төрийн болон бизнесийн байгууллагууд, хувь хүмүүс хоорондын харилцаа, цахим баримт бичиг, өгөгдөл солицохдоо Интернетийг өргөн ашигладаг боллоо. Интернет худалдаа, банк, үнэ хаялцуулах худалдаа, зуучлал, тендер хөгжиж байна. Интернетээр хоорондоо харилцахад бие биеэ харах боломжгүй байдаг учир цахим хэлбэрээр дамжуулж буй зүйлийн аюулгүй байдлыг хангах, үнэн зөвийг баталгаажуулах, бие биеэ таньж баталгаажуулах зайлшгүй шаардлага тулгардаг. Үүнийг шийдэх хэрэгсэл нь цахим тоон гарын үсэг билээ. Гэтэл тоон гарын үсгийн эрх зүйн зохицуулалт бий болоогүй учир төрийн байгууллага хооронд өгөгдөл, мэдээлэл солилцохын тулд төсвийн болон олон улсын ихээхэн санхүүжилтээр шууд холбосон шилэн кабель татах нэрээр ихээхэн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байна. Тоон гарын үсгийн хууль батлагдсанаар шууд холбосон сүлжээ татах шаардлага үгүй болж ихээхэн хөрөнгө оруулалт хэмнэх боломжтой болно.

Энэ бүх хүчин зүйлийн улмаас хуулийн төслийг олон улсын шаардлагын дагуу боловсруулах, бусад улсын хуулиудтай уялдуулан нийцүүлэх шаардлага үүсэж байна.

**Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төслийг **1. Нийтлэг үндэслэл, 2. Тоон гарын үсгийг ашиглах нөхцөл, 3. Гэрчилгээжүүлэх байгууллага, 4. Тоон гарын үсгийг ашиглах нөхцөл, 5. Бусад** гэсэн 5 бүлэгтэй 25-аас доошгүй зүйлтэй боловсруулж болно.

**Нэгдүгээр бүлэгт** хуулийн зорилт, хүрээ, цахим тоон гарын үсгийн тухай хууль тогтоомж, хуульд ашиглагдсан нэр томъёоны ойлголт,

**Хоёрдугаар бүлэгт** тоон гарын үсгийг ердийн гарын үсэгтэй адилтган үзэх нөхцөл, тоон гарын үсгийн хэрэгслийг ашиглах, гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээ, тоон гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээг гэрчилгээжүүлэх байгууллагад хадгалах хугацаа болон журам,

**Гуравдугаар бүлэгт** Гэрчилгээжүүлэх байгууллагын эрх зүйн байдал, гэрчилгээжүүлэх байгууллагын үйл ажиллагаа, гэрчилгээжүүлэх байгууллага болон төрийн эрх бүхий бүртгэгч байгууллагын хоорондын харилцаа, тоон гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээ эзэмшигчийн өмнө гэрчилгээжүүлэх байгууллагын хүлээх үүрэг, тоон гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээ эзэмшигчийн хүлээх үүрэг, тоон гарын үсгийн гэрчилгээний үйлчлэлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, гэрчилгээжүүлэх байгууллагын тусгай зөвшөөрөл, түүний үйл ажиллагааг зогсоох журам,

**Дөрөвдүгээр бүлэгт** төрийн удирдлагад тоон гарын үсэг ашиглах, тоон гарын үсгийн байгууллагын мэдээллийн системд ашиглах, тамга, тэмдгийг орлуулах тохиолдол, тоон гарын үсгийн түлхүүрийн гадаад улсад олгосон гэрчилгээг хүлээн зөвшөөрөх.

**Тавдугаар бүлэгт** Гадаадын гэрчилгээ, гарын үсгийг хүлээн зөвшөөрөх олон давхрага бүхий гэрчилгээжүүлэх байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг тусгана.

**Зургаадугаар бүлэгт** энэ хуулийн заалттай Монгол улсын хуулиудын заалтыг нийцүүлэх, гэрчилгээжүүлэх байгууллагыг байгуулах, хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариулагын тухай заалтуудыг оруулна.

**Дөрөв. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, эрх зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаархи санал**

Тоон гарын үсгийн тухай хууль батлагдсан тохиолдолд гэрчилгээжүүлэх байгууллагад тавигдах техник, эдийн засгийн шаардлагууд, тусгай зөвшөөрлийн нөхцлийг боловсруулах, шинээр үүссэн гэрчилгээжүүлэх байгууллагуудад дэмжлэг үзүүлэх, тоон гарын үсгийн хэрэглээг төрийн удирдлагад нэвтрүүлэх, төрийн албан хаагчдыг сургах, нийгмийн бусад харилцаанд нэвтрүүлэх, сурталчлах зэрэг олон үйл ажиллагаа хэрэгжүүлэх шаардлага, улмаар санхүү, эдийн засаг, зохион байгуулалт, техник технологи, эрх зүйн иж бүрэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлага үүснэ. Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтэц бий болгоход санхүүгийн ихээхэн нөөц шаардлагатай болно. Энэ санхүүжилтийг Улсын төсвөөс юмуу олон улсын санхүүгийн байгууллагын тусламж ашиглах замаар шийдвэрлүүлэх саналтай байна.

Гэрчилгээжүүлэх байгууллагын байр байшин, тоног төхөөрөмж, програм хангамжийн зардлыг энэ үйл ажиллагааг эрхлэх хүсэлтэй байгууллага өөрөө гаргах боловч үүнд төрөөс, төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх зайлшгүй шаардлагатай. Тиймээс хууль батлагдсаны дараах 2 жилийн улсын төсөвт энэ мөнгийг зайлшгүй суулгаж өгөх нь зүйтэй.

Тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийг хөгжүүлэхтэй холбогдон улсын төсвөөс гарах зардлыг тусгайлан боловсруулж, Засгийн газрын стратеги, бодлого, төслийн хүрээнд жич шийдвэрлэж байх нь зүйтэй гэсэн саналтай байна. Үүнтэй хамт нийгэм-эдийн засгийн үр дагаварын тооцоо, саналыг боловсруулж, үр ашгийг нь тооцож байх нь зүйтэй болов уу.

**Дөрөв. Хуулийн төсөл нь бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар**

Цахим гарын үсгийн тухай хууль батлагдан гарснаар Иргэний хууль, Засгийн газрын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Бүртгэлийн Ерөнхий хууль гэх зэрэг 10 гаруй хуулийн холбогдох заалтуудад нэмэлт өөрчлөлт орно.

Жич: Энэ хуулийн төсөл дэмжигдэж УИХ-д өргөн баригдах бол дээрх хуулиудад орох нэмэлт өөрчлөлтүүдийг нарийвчлан томъёолно.